

ӨМНӨХ ҮГ

Нэг. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1979 оны 389 дүгээр тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны Ардын боловсролын яам, Сангийн яамны шийдвэрээр 1980 оны 7 дугаар сарын 1-нээс Улаанбаатар хотын районуудад сургууль цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуй байгуулагдан ажилчны районы нутаг дэвсгэр дэх 14 сургууль 20 цэцэрлэгт хангамж засвар үйлчилгээнийхээ ажлыг зохион байгуулж ажиллаж ирсэн.

Сургууль цэцэрлэгийн нэгдсэн аж ахуй анх байгуулагдахдаа тооцооны болон оператор нябо 4, ахлах ня-бо 4, аж ахуйн эрхлэгч барилга сан техникийн техникч зэрэг захиргааны ажилтнаас гадна сантехник засварын 3 хэсгийн 78 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 1992 оноос сургууль цэцэрлэгүүд нь төсөвт аж ахуйн тооцоонд шилжин нэгдсэн аж ахуйн суурин дээр "Цагаан лавай" компани /УҮГ/ болон Хан-Уул дүүргийн цэцэрлэгүүдийн хангамж үйлчилгээг хангаж ажилласан. Зах зээлийн ороо бусгаа хүндрэлтэй 1993-1994 онуудад цэцэрлэгүүдийн хүнсний хангамж зогсонги байсныг дахин зохион байгуулж, 1995 оноос цэцэрлэгүүдийн хүнсний хангамжийг сайжруулан 3000 гаруй бага насны хүүхдүүдэд үйлчилж, цэцэрлэгүүд болон төсөвт газруудын цахилгаан, сантехник мужааны засваруудыг нэгтгэн зохион байгуулж, харьяа 40 гаруй байгууллагуудын төсөвт болон урсгал засварын ажлуудыг хариуцан гүйцэтгэж байна.

1997 оноос хотын хөрөнгө оруулалт мөн дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 14 цэцэрлэг сургуулиудын их засварын ажлыг нэгдсэн бригадын засварчдынхаа хүчээр бие даан хийж, нийтдээ 18 мянга гаруй хүүхэд багачууд сурч хүмүүжиж буй 1000 гаруй багш, ажилчдын ая тухтай сурч хүмүүжих орчинг бүрдүүлж ажилласан.

1999 онд Туул тосгоны 144 дүгээр цэцэрлэг 26 дугаар сургуульд халаалтын бага оврын зуух угсран монтажлаж тус компанийн цахилгаан сантехникчдийн мэргэжлийг дээшлүүлэхийн тулд дүүргийн хөдөлмөрийн биржтэй хамтран курс зохион байгуулж дулааны шугам сүлжээний газраас багш нарыг урин хичээл сургалт явуулан мэргэжлийн үнэмлэх шинэчлэн солих ажлыг жил тутам зохион байгуулж байна. Тус байгууллага нь өнөөгийн зах зээлийн нөхцөлд зохицуулан харьяа газруудыг гэрээлэн авч засвар үйлчилгээ явуулж, орон тоо цалингийн фондоо батлуулж Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулж бизнес төлөвлөгөө боловсруулан ажиллаж иржээ.

2006 оны 06 сарын 21-ний өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 154 тоот тогтоолоор "Хан-Уул хангамж" компанийг татан буулгаж 2006 оны 07 сарын 01-ний өдөр "Өсвөр үе хүнс" нэртэйгээр цэцэрлэгүүдийн хүнсний хангалтыг хариуцан ажиллах үүрэгтэйгээр ажиллаж байсан.